

хэрэгжүүлэх, хойч үедээ сайн сайхан ирээдүй байгуулах өвөг дээдсийнхээ мөрөөдлийг биелүүлэхээр хамтран ажиллах цаг ирээд байна.

**Элчин харилцаа болбаас төрийн  
алтан аргамж мөн.**

Эзэн богд Чингис хаан

МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ АЛБА ҮҮСЧ ХӨГЖСӨН ТҮҮХЭЭС  
/1911-1961 он/

Р.Янжмаа\*

ХҮI жарны цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9 буюу 1911 оны 12 дугаар сарын 29-нөөр орчин үеийн . Монгол улсын дипломат албаны шинэ цаг тооллын хуанли эхэлдэг. Чухам энэ өдөр харийн дарлалд олон зууны туршид дарлагдан талхигдан байсан монгол түмэн эрх чөлөөгөө байлдан олж, туурга тусгаар улс гэрээ төвхнүүлэн байгуулж, төр, шашны тэргүүнээрээ Богд Жавзандамба хутагтыг өргөмжилсөн билээ.

Тэрвээр Монгол улсын хаан ширээнд өргөмжлөгдмөгц төр, засгаа эмхлэх ажилд орж, таван яам байгуулан, Гадаад хэргийг бүгд ерөнхийлөн захиран шийтгэх яамны тэргүүнээ чин ван Мижиддоржийн Ханддоржийг тохоон томилж, улс орноо чөлөөлөх үйлсэд оруулсан хүчин зүтгэлийг нь үнэлэн цол, чимгээр шагнажээ.

Чин ван Ханддорж унасан газар, угаасан усандаа туйлын хайртай, ард түмнээ чин зүрхнээс хайрладаг, голч холч бодлоготон байлаа. Тэрвээр аливаа нэгэн ажлыг мэдлэг боловсролтой, түвшин нуруутай хүмүүс бүтээдэг гэж үздэг учир орчин цагийн алтан аргамжийн цогцыг бүрдүүлэн шавыг тавихдаа мэдлэг боловсролтой хүмүүсийг бүх монгол туургатан: ар, өвөр, буриад, барга, уйгар, ордос, урианхай монголчууд дотроос хайн сурвалжилж, яамныхаа цөмийг бүрдүүлж эхэлжээ.

Гадаад хэргийг бүгд ерөнхийлөн захиран шийтгэх яам Түүнийг цаашид Гадаад хэргийн яам хэмээн товчлов үйл ажиллагаагаа нийт 42 орон тоотойгоор эхэлснээс 26 нь жинхэнэ дипломат албыг хашиж байв. Гадаад хэргийг шийтгэн явуулах үүрэг бүхий яамыг бүхэлд нь тэргүүн сайд, хоёр дэд сайд, нэг эрхэлсэн түшмэл, хоёр дэс түшмэлийн хамт удирдах бөгөөд өмнөд, умард, төв 3 хэлтэс нь чиг чиглэлийнхээ үүргийг хариуцдаг байжээ. Тухайлбал, Өмнөд хэлтэс (эх зохиогч түшмэл 2, жинхэнэ бичээч 4, хятад бичиг орчуулагч түшмэл 1, хятад үсгийн бичээч 1) Дундад иргэн улстай

\* Гадаад харилцааны Яамны ажилтан.

холбогдох хэргийг шийтгэж байсан аж. Умард хэлтэс (эх зохиогч түшмэл 2, жинхэнэ бичээч 4, орос бичиг орчуулагч түшмэл 1, орос үсгийн бичээч 1) Орос улстай харилцах хэргийг шийтгэнэ. Төв хэлтэст (эх зохиогч түшмэл 2, жинхэнэ бичээч 2) олон улс лугаа хэлэлцэн тогтож гарын үсэг зурсан гэрээ бичгийн зэрэг чухал баримт бичгийг хадгалах, дотоод зэрэг олон яамны хамт зөвлөлдөн шийтгэх нийлж хэлэлцэх улс төрийн ихээхэн хэргийг эрхлэн шийтгэдэг байжээ. Жич: бүх аймаг, яам, тамгын газартай бодлогыг нэгтгэн зангидах үүрэгтэй байсныг онцлон тэмдэглүүштэй Р.Я.)

Монгол улс ийнхүү төвхнөн байгуулагдах үед хэт ирээдүйг урьдчилан харж, аливаа хэргийг ухаант хүмүүн бүтээн туурвидагийг онцлон анхаарч, төр засгийн түшээ, алтан аргамжийн эздийг бэлтгэх зорилгоор Гадаад хэргийн яамны дэргэд орос сургууль байгуулсан нь тухайн үедээ манай улсад шинэлэг зүйл байсан билээ. Тэрчлэн гадаадын улс гүрэнд хүнээ бэлтгэх бололцоог ч судалж байв. Шинээр байгуулагдан буй дипломат албанаа тухайн үедээ боловсрол, мэдлэг сайтай, тэргүүний мэдлэг боловсрол бүхий, гадаадын 1-3 хэл мэддэг тэргүүний сэхээтнүүд ажиллаж байв.

Дипломат алба байгуулагдмагц эн тэргүүнд өөрийн улсын тусгаар тогтнолыг умард, өмнөд хөршөөрөө хүлээн зөвшөөрүүлэх, цаашилбал тухайн үед дэлхийн бодлогыг тодорхойлж байсан томоохон улс гүрэнтэй харилцаа тогтоох шаггүй зорилттой тулгарсан юм. Чухам тиймээс умард, өмнөд хоёр хөршөөс гадна Америк, Англи, Франц, Холланд, Япон зэрэг улсад Монгол улсын эзэн хаанаас явуулах захидлын эхийг боловсруулж, бүх л арга замыг хайн сурвалжилж байлаа. Ерөнхий сайд сайн ноён хан Намнансүрэн, гадаад хэргийн яамны сайд тэргүүтэй төлөөлөгчдийг Орос гүрнээ явуулах бэлтгэл ажлыг хангахын сацуу Гадаад хэргийн яамны сайд Чин ван Ханддорж нийслэл Хүрээнээ хүрэлцэн ирсэн Оросын төлөөлөгчидтэй хэлэлцээ хийх бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулав.

Монголын засгийн газраас илгээсэн захидлыг оросын тал хүлээж аваад 1912 оны 8 дугаар сарын 15-нд Хаант Оросын Сайд нарын Зөвлөл «Хүрээний хутагт ба Монголын ноёдтой байгуулах гэрээний тухай асуудлыг хэлэлцэж орос-Монголын хооронд дипломат хэлэлцээ хийж, хоёр орны хооронд хэлэлцээ, хэлэлцээр байгуулах нь зүйтэй гэж үзжээ. (Тайлбарлахад, дипломат яриа хийхийг хэлэлцээ, уул хэлэлцээг албан ёсоор бичгээр буулган, гарын үсэг зурваас хэлэлцээр гэх бөлгөө. Ингээд 1912 оны 9 дүгээр сард Монгол, Оросын хооронд харилцааг зохицуулах, албан ёсны харилцаа тогтоох, улмаар Богд хаант Монгол улсыг Хаант Оросын засгийн газраар хүлээн зөвшөөрүүлэх асуудлаар Монгол, оросын хэлэлцээ Их Хүрээнд

болжээ. Уг хэлэлцээнд оролцсон оросын төлөөлөгчдийг элчин сайд Коростовец тэргүүлж байв. Хэлэлцээ нэлээд маргаантай байдалд болж, олон улсын хууль цаазны олон нэр томъёог өөр өөрийнхөөрөө тайлбарлан ярилцаж байв. Жишээлбэл, «Монгол улс», «Автономит байгуулал», «Монголын засгийн газар» зэрэг томъёоллыг хоёр тал өөр өөрийнхөөрөө тайлбарлан ойлгож байжээ. Салаа утгатай, бүрхэг томъёоллыг хэрэглэх замаар хоёр тал бие биендээ буулт хийж 1912 оны 10 дугаар сарын 21-нд Гэрээ бичгийг байгуулжээ. Үүнээс Хэдхэн сарын өмнө буюу 1912 оны 7 дугаар сарын 8-наас Орос, Японы хооронд нууц хэлэлцээ явагдаж, мөн оны 7 дугаар сарын 25 нд Монголын тухай Орос-Японы гуравдугаар нууц гэрээ Петербург хотноо байгуулагджээ. Сазанов - Мотоногийн гэдэг уг гэрээнд Орос, Япон хоёр Монгол дахь нөлөөнийхөө хүрээг Бээжингийн уртрагаас зүүн баруун тийш зааглан хуваав. Энэ бол Өвөр Монголыг хоёр хуваасан хэрэг байлаа. Үүнээс өмнө Ар Монголыг Оросын нөлөөний бүсэд хамруулахаар Япон улс зөвшөөрч 1907 онд гэрээ байгуулсан байсан аж.)

Орос улстай байгуулсан гэрээгээр улсынхаа нэрийг «Монгол улс» хэмээн оросын талаар хүлээн зөвшөөрүүлсэн явдал бол Монголын улс төрчид, дипломатуудын томоохон амжилт байлаа. Гэвч харамсалтай нь 1913 онд Орос, Хятадын хооронд байгуулсан Гэрээгээр хятадын шахалт дор буулт хийж оросын тал «Монгол улс» гэдэг нэр томъёоноос татгалзаж, «Ар Монгол» гэж нэрлэх болжээ.

Монгол улсыг бие даасан улс гэдгийг хүлээн зөвшөөрч, тусгаар тогтнох их үйлсэд тусласныг нь харгалзан Оросын талд олон улсын хууль цаазны нэр томъёогоор «үндэсний нэн тааламжтай нөхцөл» буюу гаалийн хөнгөлөлт үзүүлэхээр болжээ. Уг гэрээний заалт бүрийг хууль эрхийн үүднээс өнөөдрийн өндөрлөгөөс харахад том, жижиг хоёр орны хооронд анх түрүүн байгуулсан гэрээ гэхэд монголын талд найр тавьсан нэлээд заалт байдаг. Жишээлбэл:

Монголын эд барааг Оросын нутгаар дамжуулан гуравдахь оронд гарган борлуулахад гаалийн хөнгөлөлт үзүүлэх г.м. Гэрээ, түүний хавсралт протоколоор орос худалдаачдын Монголд гаальгүй худалдаалах онц эрхийг баталжээ. Чухамдаа монголын тал ийм буулт хийснээрээ улс төрийн хувьд хожиж, олон зууны дараа сэргээсэн тусгаар тогтнолоо гадаадын томоохон гүрнээр хүлээн зөвшөөрүүлж чадсан бөлгөө.

1912 оны өвлийн сүүл сарын шинийн 4-нд Богд хаант Монгол улсын гадаад хэргийг бүгд ерөнхийлөн шийтгэх яамны тэргүүн сайд Чин ван Ханддорж тэргүүтэй Монголын бүрэн эрхт төлөөлөгчид Петербургт очлоо. Энэ бол туурга тусгаар Монгол улсын төлөөлөгчдийн гадаад улс гүрэнд хийж буй анхны албан ёсны айлчлал байв. Монголын төлөөлөгчид Хаант Оросоос зээл, зэвсэг,

цэргийн сургагч авах, Өвөр Монголыг чөлөөлөн монгол овогтныг нэгтгэх хэрэгт дэмжлэг үзүүлэх хүсэлт тавих, дипломат төлөөлөгчдөө харилцан суулгах, мөн Петербург дэхь гадаадын улсуудын элчин сайдуудтай уулзан, найрамдлын харилцаа тогтоох, улмаар Англи, Франц зэрэг Өрнөд Европын зарим оронд биеэр хүрч очин Монгол улсыг хүлээн зөвшөөрүүлэх асуудлыг тавих зорилготой байв. Айлчлалын дүнд Хаант Оросоос 2 сая рублийн зээл, бага хэмжээний зэвсэг авахаар болжээ. Харин бусад зорилго нь төдийлөн амжилт олж чадсангүй.

1913 оны 1 дүгээр сард Богдын засгийн газар, Түвдтэй найрамдлын гэрээ байгуулав. Тус гэрээнд «Бидний Монгол, Түвд хоёр улс Чин улсын мэдлээс гарч, Хятадаас салаад тус бүр өөртөө эзэрхэх улс төр байгуулсан нь эрт цагаас эдүгээ хүртэл Монгол, Түвд хоёр шашин нэгтэй, харилцан онц найрамдалтай бөгөөд одоо улам зузаатгахыг эрмэлзэж гэрээ бичиг тогтоосон нь:

Монгол Улсын Хаан эзний зарлигаар гэрээ хэлэлцэх эрх олгогдсон сайд, гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны хамаарсан тэргүүн сайд даа лам нягт билэгт Равдан, дэд сайд, цэргийн жанжин манлай баатар бэйл Дамдинсүрэн, Түвд улсын хаан эзний зарлигаар гэрээ хэлэлцэх эрх өгөгдсөн түшмэл хүчир Цайсаб, хасчин Лувсанхайдав донир нар:

Нэгдүгээр зүйл «Монгол улсын Өөртөө эзэрхэх улс төр (бүрэн эрхт улс Р.Я.) байгуулж, шарын шашины эзэн Жавзандамба ламыг улсын Хаан эзэнд гахай жилийн арван нэгэн сарын шинийн есний өдөр өргөмжилснийг Түвд улсын Хаан эзэн Далай лам сайшаан зөвшөөрч батлав.

Түвдүүд өөртөө тохинон тус улс болоод Далай ламыг Хаан эзэнд өргөмжлөхийг Монгол улсын Хаан эзэн Жавзандамба лам сайшаан зөвшөөрч батлав.

Монгол, Түвд хоёр улс энэ цагаас эхлэн үүрд гадна, дотнын аюул учирваас нэг нэгнээ харилцан тусламуй» гэжээ.

Энэхүү гэрээ нь бага буурай улс түмэн харийн дарлалыг эсэргүүцэн, тусгаар тогтнолынхоо тэмцэлд харилцан бие биедээ дэмжлэг үзүүлэх гэсэн эрмэлзлийн илрэл болж, туурга тусгаар Монгол улсыг хүлээн зөвшөөрсөн хоёр дахь улс нь Түвд болов. Гэхдээ олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хууль цаазны дагуу болвоос Монгол улсыг бие даасан тусгаар улс гэж Түвд улс анх түрүүнд хүлээн зөвшөөрчээ.

1913 оны эхээр Дотоод яамны тэргүүн сайд даа лам Цэрэнчимэд, Бүгд ерөнхийлөн захирах яамны дэд сайд Гомбосүрэн нар Японтой харилцаа тогтоох асуудлыг хэлэлцэхээр Токио руу

морджээ. Гэтэл замд нь Хаант Орос болон Хятадын тал саад хийснээс болж тэд Харбинаас цааш явж чадаагүй байна. Тэгээд ч Япон улс Оростой байгуулсан 1912 оны Гэрээгээр хүлээсэн үүргээрээ Монгол дахь Оросын онц ашиг сонирхлыг хамгаалах нэрийдлээр Монголын төлөөлөгчдийг хүлээн авч чадахгүйгээ мэдэгдсэн ажээ.

1913 оны 10 дугаар сарын 23-нд «Гадаад Монголын автономыг хүлээн зөвшөөрөх тухай Орос, Хятадын тунхаг»-т Бээжин хотноо гарын үсэг зуржээ. Таван зүйлээс бүрдсэн энэ тунхагт Гадаад Монголыг Хятадын эзэгнэллийн (сюзеренитет) дор оршихыг Орос зөвшөөрч, Гадаад Монголын автономыг Хятад зөвшөөрөхөөр тохиролцсон нь хэрэг дээрээ Монголын тусгаар тогтнолоор панз хийсэн хэрэг байлаа. Үүнийг Япон улс битүүхэн дэмжиж байв.

Богд хаант Монгол улсын засгийн газар уг тунхагийг эсэргүүцэн Монголын Гадаад Яам Хаант Орос, Хятадын засгийн газарт 1913 онд ижил үг үсэг бүхий ноот явуулжээ. Уг ноот бичигт «Монгол улсын хэргийг Монгол улсын засгийн хэрэг шийтгэх газар лугаа зөвлөхгүйгээр шууд хэлэлцэх нь ердийн цаазыг тэрслэхийн Дээр хэрхэн тогтоох боловч манай улс хэрхэвч хүлээж чадахгүй» гэжээ. Мөн Оросоос Хүрээнд зарагдан ирсэн онц эрхт элчин сайд Коростовецэд эсэргүүцлийн бичиг гардуулав. Уг бичигт «бидний хувьд гэвэл үүний урьд танай улстай тогтоосон гэрээ бичгийг шударга ёсоор дагаж, юу боловч Хятадтай нийлэхгүй бөгөөд манай зорилтыг биелүүлэхэд эрхэм улс эрхбиш туслахыг хүснэ» гэжээ. 1913 оны 11 дүгээр сарын 4-нд Монголын засгийн газар Их Хүрээн дэх Хаант Оросын консулд мөн эсэргүүцлийн ноот явуулж, түүндээ Монголыг Хятадын хэмжээт эзэрхийллийн дор оруулахыг огтхон ч хүлээж авахгүйгээ дахин мэдэгджээ.

1913 оны эцсээр Богдын засгийн газар ерөнхий сайд сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчдийг Петербургт дахин томилон илгээв. Энэ удаагийн элч төлөөлөгчдийн зорилго бол Хаант Орос улсаас зэр зэвсэг, санхүүгийн тусламж нэмж авах, Ар, Өвөр Монголын нэгдлийг дахин сэргээх хэрэгт дэмжлэг олох, Петербург дэх гадаад орнуудын дипломат төлөөлөгчдийн газартай холбоо тогтоож, Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх явдал байлаа. Оросоос дахин 3 сая рублийн зээл авах тухай тохиролцож чадав. Петербург дэх гадаад орнуудын дипломат төлөөлөгчийн газруудтай холбоо тогтоох асуудал аанай л хэрэгжсэнгүй. Энэ айлчлалын үеэр Хаант Орос олгосон зээлийн зарцуулалтад болон ерөөс Хүрээний засгийн газрыг улс төр - Эдийн загсийн талаар хянаж байх тусгай түшмэлийг Их Хүрэнд суулгах асуудлыг оросын тал манай төлөөлөгчдөд тулган хүлээлгэжээ. Үүний дагуу С.Козин 1914 онд Монголд томилогдосон иржээ.

1913 оны 11 дүгээр сард Монголын засгийн газар Японтой харилцаа тогтоох асуудлыг оросын талаар зуучлуулахыг оролдсон авч оросын тал эрс татгалзсаны улмаас хэрэгжсэнгүй. Мөн оны эцсээр Японы иргэн Кодама (үүнийг нууц нэр нь гэж америкийн судлаач Эвинг «Орос, Хятадын хоорондын 1911-1921 оны харилцаа» гэдэг номондоо өгүүлсэн бий) гэгч Их Хүрээнд ирж, Монголын эрх баригчидтай уулзжээ. Ерөнхий сайд Намнансүрэн, чин ван Ханддорж нар Кодамаг албан бусаар хүлээн авч, Японтой албан ёсны харилцаа тогтооход зуучилж өгөх асуудлыг хөндсөн боловч тэрвээр гагцхүү худалдаа наймааны хэргээр яваа хэмээн цааргалсан аж. (Ц.Батбаяр «Кодама Их Хүрээнд» номоос) Кодама Их Хүрээнд байх хугацаандаа Монголын талаар биечлэн нэлээд судалгаа хийсний дээр Орос, Хятадын албаны хүмүүстэй уулзаж ярилцсан ажээ.

1913 оны 12 дугаар сарын 9-нд Их хүрээнд америкийн дипломатч Рокхиль ирж, хоёр хоног байхдаа манай зарим сайд, ноёдтой уулзжээ.

1914 оны хавраас эхлэн Богдын засгийн газар Бээжин дэх гадаад улсуудын элчин сайд нараар дамжуулан Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх, харилцаа тогтоох оролдлого дахин хийсэн боловч амжилт олсонгүй. Ер нь Монгол улсын тусгаар тогтнолыг бусад улс гүрнээр хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө бүгд хичээнгүйлэн зүтгэж байлаа. Жишээлбэл, Хайсан лам Оросоос өөр улс манайхыг зөвшөөрөхгүй аваас Гаагийн бага хуралд биеэр очиж, их гүрнүүдээр дэмжүүлэхийг хүсч байжээ.

1914 оны 3 дугаар сарын дундуур Хөлөнбуйрт гадаад улстай харилцах хэлтэс байгуулав. Хөлөнбуйрт ийнхүү байгуулсаны шалтгаан нь Их Хүрээн дэх Оросын консулын хараанаас ангид байх, нөгөөтэйгүүр гадаадынхантай харилцахад арай дөхөмтэй байсан зэргийг бодолцсон хэрэг буй заа.

1914 оны 8 дугаар сарын 26-наас 1915 оны 5 дугаар сарын 25 ны хооронд Хиагт хотод Монгол улс Хаант Орос улс, Дундад иргэн улсын гурамсан хэлэлцээ болов. Гурван улсын хэлэлцээгээр Монголын асуудлыг авч хэлэлцэн, харилцан адилгүй байр суурь, бодлого баримталсан талууд удтал маргалдсаны эцэст (40 гаруй хуралдаан хийсэн) Орос, Хятад хоёр гүрэн нэгдсэн хүчээр Монгол улсыг буулган авч, Хятадын автономит эрхтэй муж улс хэмээн зөвшөөрүүлсний дээр гадаад харилцаа эрхлэн явуулах эрхийг нь хассан ажээ. Энэ хэлэлцээ ид халуун, өрнөж байх тэр өдрүүдэд Монгол улсын гадаад хэргийн сайд чин ван Ханддорж хар санаатанд хорлогджээ.

Хиагтын хэлэлцээнд манай төлөөлөгчдийг жүн ван Ширнэндамдин тэргүүлэн оролцож, Орос, Хятад хоёрын тавьсан тулгалтыг хүлээн авахаас татгалзаж байсан тул хэлэлцээний сүүлийн шатанд гаднын шахалтаар аргагүй түүнийг өөрчилж байсан байдаг. Түүнээс гадна гадаад хэргийн яамнаас бэйс Б.Цэрэндорж, А.Амар, нарын дипломатчид оролцож байв. Жүн ван Ширнэндамдин бол алтан аргамжийн бодлого, үйл ажиллагааг давхар давхар бүрээстэй байлгахыг хичээдэг, туйлын хашир дипломатч байсан агаад сүүлд 1921 онд Зөвлөлт Орос улстай хийсэн хэлэлцээнд Богд хааны бие төлөөлөгчөөр оролцож явсаны дээр насан эцэс болтлоо улс орныхоо тусгаар тогтнолын төлөө хичээнгүйлэн зүтгэж явжээ.( түүнийг 1930 онд улс төрийн хилс хэргээр хэлмэгдүүлжээ)

Хэдийгээр энэ гэрээгээр Монгол улс гадаад харилцаагаа явуулах эрхгүй болж, үйл ажиллагаа нь хумигдах болсон ч гэсэн 1919 он хүртэл гадаад хэргийн яам хуучин бүрэлдэхүүнээрээ ажилласаар байжээ.

Гадаад хэргийн яам үйл ажиллагаагаа гагцхүү улс төрийн асуудлаар хязгаарлаж байсангүй, харин эдийн засаг - худалдааны харилцаанд ихэд анхаарч, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад улс гүрний худалдаа-эдийн засгийн пүүс хоршоодын төлөөлөгчдийг Монголд ажиллуулах таатай нөхцөлийг бүрдүүлэхийг хичээж байлаа. Энэ хугацаанд манай улсад Америк, Дани, Герман зэрэг нэлээд олон орны пүүс хоршоод ажлаа явуулж байв. 1916 онд Их Хүрээ, Чуулалт Хаалганы хооронд авто тээврийн компани нээх оролдлогыг америкчууд хийсэн боловч оросуудын шахалтаар Богдын засгийн газар зөвшөөрч чадсангүй.

1915-1917 онд Тагнын Урианхайн асуудлаар Хятад, Хаант Оросын болон Зөвлөлт Оросын хооронд удаа дараа хэлэлцээ яриа хийх, албан бичиг захидлаар харилцах зэргээр ярилцаж байсан авч тодорхой үр дүнд хүрэхгүй байв. Манж, оросын хоорондын 1727 оны Хиагтын гэрээ, 1851 оны Кульжийн худалдааны хэлэлцээр, 1860 оны Бээжингийн нэмэлт гэрээ, 1881 оны Санкт-Петербургийн гэрээ зэргээр оросын тал Монголд худалдаа хийх, консулын газраа нээх эрх олж авсныгаа далимдуулан Тагнын Урианхайг колоничлох бодлого явуулж, тэнд оросуудыг олноор нүүлгэн суурьшуулж, урианхай монголчуудыг уугуул нутгаас нь шахан, эрдэст болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийг дур мэдэн бэлтгэн худалдаалж байсныг Их Хүрээ эсэргүүцэн Тагнын Урианхайг Монголын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн хэмээн үзэж ихэд дургүйцэж байсан юм. Тагнын Урианхай тэр үед засаг захиргааны хуваариар Ховдын хязгаарын бүрэлдэхүүнд багтаж байлаа. 1890-ээд онд тэнд нүүн суурьшсан оросуудын тоо 1500 байсан бол 1912 он гэхэд 10 гаруй

мянгад хүрч, алтны орд газрыг эзэмшин олборлож, ангийн үнэт үс, малын гаралтай түүхий эдийн борлуулалтад дангаар эзэмших эрх олж аваад байсан байна. Үүнд дургүйцсэн урианхайчууд Тагна уулыг даван урагшлан нүүж байсан ажээ. 1919 оны 9 дүгээр сард Хатанбаатар Магсаржав Дилав хутагт Жамсранжавын хамт Тагнын Урианхайг тохинуулахаар цэрэг хөдөлгөн очиж, оросуудын нүүдлийг хязгаарлахад нөлөө үзүүлж чадсан ажээ.

1917 онд Орос улсад хувьсгал гарч, большевик-коммунист намынхан засгийн эрхийг авсан бөгөөд энэ үед Алс Дорнодын байдал туйлын ээдрээтэй болсон билээ.

Япон улс Алс Дорнод дахь нөлөөгөө алдахгүй байх, коммунистуудын нөлөөг тэнд нэвтрүүлэхгүйн тулд атаман Семенов хийгээд Японыг талархагч хүчнийг дэмжих бодлого явуулж байв. Тэрчилэн бүс нутаг дахь урьд өмнөх байдлыг хадгалах зорилгоор 1918 оны намар Япон, Хятад хоёр нууц хэлэлцээр байгуулж, түүндээ Ар Монгол дахь Хятадын сонирхлыг хангах, өөрөөр хэлбэл Монгол улсыг Хятадын харъяат болгоход Япон улс татгалзахгүй гэсэн байр суурь илэрхийлсний учир Орос дахь коммунизмын нөлөөнөөс урьдчилан сэргийлэх нэрийн дор Хятадууд Монголд цэргийн хүчээр түрэмгийлэхэд саад хийхгүй гэсэн амлалт өгчээ.

Оросын тал 1917 оны сүүлчээс Хаант Оросоос бусад улс гүрэнтэй байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийг цуцлах дэлхий нийтэд зарлахын сацуу 1919 оны 4 дүгээр сард Орос, Хятадын хооронд болсон нууц хэлэлцээгээр түрүүчийн засгийн бүх гэрээ хэлэлцээр, түүний дотор Монголтой 1912, 1913, 1915 онд байгуулсан гэрээ хэлэлцээрийг хүчингүй болгосон тухайгаа хятадын талд мэдэгджээ. Чухам энэ нь Монголын асуудлаархи түрүүчийн байр сууринаасаа татгалзлаа гэсэн үг байлаа. Яг ийм үед Монгол улсынхаа тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч сайн ноён хан Ерөнхий сайд Намнансүрэн, Гадаад хэргийн сайд чин ван Ханддорж нарын зүтгэлтнүүд амь хороогдсон нь манай улсын улс төрийн зүтгэлтнүүдийн дотор болгоомжлох байдлыг бий болгосон гэлтэй. Оросын дотоодын хямралаас шалтгаалан Монгол, оросын хоорондын худалдаа зогсож, Монголд гүйж байсан орос рублийн ханш унасан нь эдийн засгийн байдалд муугаар нөлөөлжээ. Нөгөөтэйгүүр эзэн хаанаа түлхэн унагаж, шашин номондоо цөв оруулсан тухай мэдээ Монголын ноёд түшмэд, дээд лам нарын дундах өмнөд хөршийг түншлэхийг эрмэлзэгчдийг идэвхжүүлсэн бололтой.

Ар, Өвөр, Буриад Монголын төлөөлөгчдийн хурилдай 1919 онд болж, Дагуурын засгийн газрыг байгуулав. Хэдийгээр Монгол

төрийн тэргүүн-Богд Жавзандамба хутагт, түүний засгийн газрын албан ёсны төлөөлөгч томилогдон очоогүй ч уг үйл явдлыг туйлын анхааралтай ажиглаж байв.

Гэтэл Хятад улс 1919 оны намар Монгол руу цэрэг зэвсгийн хүчээр түрэмгийлж, 1919 оны 11 дүгээр сарын 22-нд автономитыг устгасан тухай тунхаг гэгчийг ард нийтэд зарлажээ. Ингэснээр Монгол улс Хятадын эзэмшилд орж, төрийн яамдыг тараан буулгасан юм. Гадаад хэргийг бүгд ерөнхийлөн шийтгэх яам тарж, тэргүүн сайд Б.Цэрэндорж, түшмэл А.Амар нарын дипломатчид хөдөө нутагтаа буцсан байна.

Тусгаар тогтнолынхоо төлөө, хятадын империалистуудын эсрэг хийсэн Монголын эх орончдын 1912-1918 оны тэмцэл Сайн ноён хан Намнансүрэн, да лам Цэрэнчимэд, чин ван Ханддорж нарын үхлээр төгссөн юм гэж В.Л.Попов гэгч бүр 1923 онд бичиж байжээ. /ф.Чичерина,оп.5,пор.4,пап. 107 а/

Гэвч тэмцэл зогсоогүй, нууц байдалд урьд урьдаас илүү эрчимтэй өрнөж эхэлжээ. 1919 оны өвлийн сүүл сараас бүрэн эрхт байдлаа сэргээн мандуулахын төлөө бүхий л аргаар хичээн оролдож эхэлжээ.

1920 оны эхээр Богд Жавзандамба хутагт лүндэн буулгаж, ноёд түшмэдийг Их Хүрээнээ хуруулан, автономит эрхийг сэргээх асуудлаар Бээжин рүү Дилав хутагт Жамсранжав нарын арван хүний бүрэлдэхүүнтэй элч төлөөлөгчид явуулахаар шийдвэрлэж байсан боловч Хятадын тал татгалзсаны учир төлөөлөгчдийг мордуулж чадаагүй ажээ.

1920 оны өвлөөс Оросын цагаантан барон Унгерний цэрэг Монголын зүүн хойд хязгаараар цөмрөн орж ирсэн бөгөөд 1921 оны 2 дугаар сарын 3-нд тэд нийслэл Хүрээг эзэлж, Хятадын цэргийн эрхтэнд баригдаад байсан Богд Жавзандамба хутагтыг суллаж, Богд Гэгээний Засгийн газрыг сэргээн тогтоосон тухай зарлав.

Хятадын цэргийн эзэмшлээс эх орноо чөлөөлж, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн мандуулах зорилго бүхий хүчнүүд Монгол даяар байсан боловч хүчээ нэгтгэж чадахгүй байлаа. Хатанбаатар Магсаржав, Жамъян гүн, Дилав хутагт Жамсранжав, Гомбо-ичин (Гомбо-Идшин гэж бас бичдэг) нарын эх орончид Хятадын хар цэргээс эх орноо хэрхэн нөлөөлөх талаар ярилцан зөвлөлддөг төдийгүй сор залах зэрэг шашины зан үйл хэрэгжүүлдэг байсан аж.

Бодоо 1920 оны дундуур Дилав хутагттай холбоо тогтоон, түүний зөвлөснөөр Орос руу явахдаа Богдын гарын үсэг, тамга бүхий захидал авч явахаар болжээ.(Г.Дүйнхэржав «Наян дөрвөн шидэтний нэг - Дилово хутагт» 1991 он, Улаанбаатар)

1920 оны зун, намрын үест Америкийн нэгэн албаны хүн Их Хүрээнээ ирэх үед түүнтэй Жалханз хутагт уулзаж байжээ. Дайчин ван Жалцан, Дилав хутагт Жамсранжав, Хатанбаатар нар эхийг нь боловсруулсан тусламж хүссэн захидлыг Жалханз хутагт америкийн тэр албаны хүнд өгсөн мэдээ байдаг боловч түүний хариу ирсэн эсэх нь тодорхойгүй байдаг. Бас Жалханз хутагт Дамдинбазар 1920 онд Далай ламын төлөөлөгчөөр дамжуулан Англид захидал явуулж байсан гэдэг.

Их Хүрээнээ 1919 оны дундуур буюу хятадын цэрэг Монголыг эзэлсэний дараахан байгуулагдсан эх орончдын буюу сүүлд «ардын хувьсгалчдын» гэж нэршсэн хоёр бүлгэм хоорондоо нийлж, Монгол орноо чөлөөлөхийн тулд хаанаас тусламж гуйх талаар санал бодлоо солилцож байв. Богд хаант улсын үед хоёр хөршөөс гадна дэлхийн бусад улстай холбоо тогтоон, тэднээс дэмжлэг тусламж авах хүсэл талаар болж байсныг бодитойгоор харгалзахын сацуу дэлхийн бага буурай улс гүрэн тусгаар тогтнон хөгжихийг дэмжинэ гэдгээ амалж байгааг нь харгалзан Зөвлөлт Орос улсад хандахаас өөр аргагүй гэдгийг нийтээрээ нэгэн саналаар зөвшөөрч байв.

1921 оны 3 дугаар сарын 24-нд Ардын түр засгийн газар байгуулагдахад ДЯЯ-ны харъяанд гадаад хэрэг эрхлэх хэлтэс байгуулжээ.

1921 оны 7 дугаар сарын 10-нд Нийслэл Хүрээг харийн түрэмгийлэгчдээс чөлөөлсний дараа Богд эзэн хаантай тангаргийн гэрээ байгуулан, төр, шашины эрх мэдлийг хуваарилан Ардын засгийн газар байгуулагдлаа.

Ардын засгын газрыг 1911 оны адил гадаад, дотоод, цэрэг, сан, шүүх гэсэн таван яамтай байгуулан, ерөнхий сайд бөгөөд гадаад хэргийг бүгд ерөнхийлөн захирах яамны сайдаар Д.Бодоог тохоон томилсон билээ.

Засгийн газрын хуралдаанаар ГЯЯ-ны бүтэц зохион байгуулалтыг хэлэлцээд ерөнхий, өрнөд, дорнод, цахилгаан мэдээ, шуудан бичгийн гэсэн дөрвөн хэлтэс, нийт 71 орон тоотой байхаар баталж байсан боловч тухайн үеийн санхүүгийн болон хүн хүчний боллоцооноос 37 хүнтэйгээр ажлаа явуулж эхэлсэн байна.

1921 онд ГЯЯ-нд тэргүүн сайд Бодоогоос гадна дэд сайд бөгөөд эрхэлсэн түшмэлээр гүн Жигмэддорж, дэд сайд орлосон гүн Наваанамжил, эрхэлсэн түшмэл гүн Цэрэндорж, эрхэлсэн түшмэл орлосон гүн Дашаа, туслах түшмэл гүн Гүржав, туслах түшмэл гүн Самбуу, туслах түшмэл орлосон туслагч Магсаржав, туслах түшмэл орлосон Сүндэвдоной, туслах түшмэл орлосон залан Болод, туслах түшмэл орлосон Өсөхбаяр, Түмэнбаяр, хятад хэлний орчуулагч түшмэл Элбэгбат, орос бичгийн орчуулагч бөгөөд хэвлэх машины бичээч Гарамжав, Попов, дээд зэргийн бичээч Чимид, Балдансанжаа, Догсом, Дэлэгням, Догсүрэн, дунд зэргийн бичээч Сандуйжав, Цэвэгжав, Ядамсүрэн, Түвдэн, нярав Цэрэн, зарлагын зэрэг орос хэлмэрч Янжин, хятад хэлмэрч Дачин, зарлага Гүтрээ, Галсан, Дамдин, Нэмэх, Содномпунцаг, хөдөлмөрчөөр Дорж, Намжил, Санжаа, Пэрэнлэй, Намжил нар ажиллаж байжээ. Эдгээрийн 10 нь автономитын үед дипломат алба хашиж байсан туршлагатай хашир дипломатчид байсан аж.

Монгол улсын дипломат алба ийнхүү сэргэн байгуулагдан 1929 оныг дуустал бараг энэ бүтэц, зохион байгуулалтаар ажиллаж байв.

Ардын засгийн газар байгуулагдмагцаа юун түрүүнд нутаг дэвсгэрээ харийн түрэмгийлэгчдээс бүрэн чөлөөлөх, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа гадаадын бусад улс гүрнээр хүлээн зөвшөөрүүлэх зорилт тавьж, Ерөнхий сайд бөгөөд гадаад хэргийн сайд Д.Бодоо 1921 оны 7 дугаар сарын сүүлчээр Зөвлөлт Орос улс, Хятад улсад, 9 дүгээр сард Америк, Англи, Япон, Франц зэрэг дэлхийн томоохон улс орнуудад хандан Монгол улс тусгаар тогтносныг зарлан мэдэгдэж, тэдгээртэй найрсаг харилцаа хөгжүүлэх хүсэл эрмэлзлээ илэрхийлэв.

Монгол, Зөвлөлт Оросын албан ёсны анхны хэлэлцээ 1921 оны 10 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 5-ны өдрүүдэд Москва хотноо болсон билээ. Хэлэлцээнд монголын талаас МАН-ын дарга, Монгол улсын ерөнхий сайдын орлогч бөгөөд сангийн яамны сайд Солийн Данзан төлөөлөгчдийг тэргүүлж оролцсон. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд бүх цэргийн жанжин, цэргийн яамны тэргүүн сайд Д.Сүхбаатар, ГЯЯ-ны дэд сайд Б.Цэрэндорж нараас гадна Богд хааны бие төлөөлөгчөөр жүн ван Ширнэндамдин оролцжээ. Энэ хэлэлцээ яриа нэлээд хурц халуун болсон бөгөөд Монголын төлөөлөгчдийн тавьсан зарим асуудал, тухайлбал Тагнын Урианхайн асуудлыг албан ёсны хэлэлцээний тэмдэглэлд оруулаагүй байдаг. Монголын төлөөлөгчдийн тэргүүн хэлэлцээний анхны өдрийн уулзалт дээр 9 зүйлт мэдэгдэл хийсэн бөгөөд түүнд Монгол улсын тусгаар тогтнолыг Зөвлөлт Орос улс хүлээн зөвшөөрөх, туурга тусгаар төр улсыг

төвхнүүлэхэд шаардагдах хөрөнгө мөнгөний дэмжлэг үзүүлэхийг хүсчээ.

Тэрчилэн буриадуудыг Монголд дагаар оруулахад татгалзахгүй байх, Тагнын Урианхайг Монголд нэгтгэх зэргийг хүссэн байна.(Эдгээр асуудлыг С.Данзан бүр 1920 онд оросын төлөөлөгчидтэй уулзахдаа тавьж байсан байдаг)

Хэлэлцээний дүнд Монгол улс, Зөвлөлийн засагт Орос улсын хооронд найрамдлын барилдлага тогтоох тухай Гэрээ, Автономитын үеийн Хаант Оросын санхүү, худалдааны онц эрхийг устгах тухай Протокол, Монголын мөнгөн тэмдэгтийг үйлдвэрлэх тухай гэрээ зэрэг баримт бичигт гарын үсэг зурав. Найрамдлын барилдлага тогтоох тухай гэрээний нэгдүгээр зүйлд «Зөвлөлийн засагт Орос Улсын засгийн газраас гагцхүү хуулийн ёсоор эрх барьсан Монгол ардын засгийн газрыг», хоёрдугаар зүйлд «Монголын ардын засгийн газраас гагцхүү хуулийн ёсоор эрх барьсан Зөвлөлийн Засагт Орос улсын засгийн газрыг» тус тус хүлээн зөвшөөрчээ.

Монголын дипломатчид, улс төрчдийн гол чухал зорилт бол Монгол, Хятадын харилцааг хэвийн болгож, Монгол улсын тусгаар тогтнолыг Хятад улсаар хүлээн зөвшөөрүүлэх явдал байлаа. Иймээс бүр 1921 оноос эхлэн эл асуудалд зуучлуулахаар аль орныг сонгох вэ гэдэг асуулт гарч байв. Орос улсаас дэмжлэг олохын сацуу бусад улс гүрнээр давхар баталгаажуулах нь зүйтэй хэмээн үзэж байв.

1921 оны 12 дугаар сард Хятадын шуудан холбооны төлөөлөгчид гэж ирсэн бөгөөд Бодоотой уулзахдаа Монгол, Хятадын харилцааны асуудлыг хөндөж ярилцжээ. Монгол, Хятад хоёр харилцаагаа өөр хоорондоо хөндлөнгийн зуучлалгүйгээр хэлэлцэн шийдвэрлэх хэрэгтэй гэж ухуулах зорилготой ирсэн байна. Ерөнхий сайд Бодоо мөн асуудлыг хөндөж 1919 онд Сю Шүжаны цэргийн дарангуйллын гашууун туршлагаас монголчууд сургамж авснаа шууд хэлж байсан байдаг.

1921 оны 8 дугаар сард Чуулалт хаалган дахь Америкийн консул Сокобин Их Хүрээнд хүрэлцэн ирж, сар гаруй байхдаа шинэ засгийн газрынхантай уулзаж, Монгол, Хятадын хооронд зуучилж өгөх асуудлыг тавин зарчмын зөвшилд хүрсэн аж. Уг асуудал хийгээд АНУ-тай харилцаа тогтоох асуудлаар ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Д.Бодоо 1921 оны 9 дүгээр сард Богд хааны тамгатай бичгийг америкийн консулд гардуулсан байна. 1922 онд америкийн консул Сокобиныг Монголд дахин ирэхэд нь Ерөнхий сайд Жалханз хутагт Дамдинбазар хүлээн авч уулзахдаа Монгол, Хятадын хоорондын харилцааг хэвийн болгоход зуучлах амлалтаа

Америк улс хэрхэн биелүүлж байгааг лавлахад АНУ Монгол руу орох цаг нь арай болоогүй хэмээн хариулсан тухай мэдээ байдаг.

1921 оны 12 дугаар сард Д.Бодоо Хятадын шуудан холбооны төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, Монгол, Хятадын харилцааны асуудлыг хөндөж ярилцжээ. Хятадын төлөөлөгчид хоёр орны харилцааг хөдлөнгийн зуучлалгүйгээр хэлэлцэн шийдвэрлэх санал тавьсныг манай тал няцаажээ.

Монгол, Хятадын хооронд зуучилж өгөх гэсэн америкчуудын хүсэлт нь энэ талаар өөрсдөө түрүүлж хүсэлт гаргахаас өөр аргагүй байдалд оросуудыг оруулсан байна. Тиймээс тэд ардын засгийн газрынханд нөлөөлж тийм хүсэлтийг гаргуулж авсан байна. (ГХТА, Ф.02 х/н 130, 66-68 дугаар хуудас)

1922-1924 нд Орос, Хятадын хооронд харилцаагаа хэвийн болгох асуудлаар явагдсан хэлэлцээн дээр Монголын болон Алс Дорнод дахь төмөр замын тухай асуудал нэлээд чухал байр эзэлж байсан билээ. Энэ хэлэлцээн дээр Монголын эрх ашиг ноцтойгоор зөрчигдөн Монгол улсыг автономит эрхтэй улс болгох, тэр бүү хэл Хятадын бүрэлдэхүүн хэсэг хэмээн зөвшөөрөх хандлага гарч ирсэн байна. Иймд манай ГЯЯ-ны сайд бэйс Б.Цэрэндорж 1922 оны 11 дүгээр сарын 30-нд Зөвлөлт Орос улсын бүрэн эрх барих төлөөлөгчийн газарт дараах агуулгатай ноот илгээв. (No413) Үүнд: «Сүүлийн үед гадаадын хэвлэлд Хятад дахь ЗОУ-ын бүрэн эрх барих төлөөлөгч Бээжингийн засгийн газартай Монголын асуудлаар урьдчилсан хэлэлцээ яриа хийхдээ дараах санаа бодлыг илэрхийлсэн тухай мэдээ гарч байна. Чухам юу хэмээвээс: Автономит Монголын тухай гурван гүрний түрүүчийн гэрээ бичгийг Монгол улсын байгууллын талаарх хэлэлцээ яриандаа үндэслэнэ гэжээ. Монгол улсыг тусгаар тогтносон эрх чөлөөтэй улс байхыг хүсдэггүй, Орос, Монголын засгийн газар, ард түмний хооронд яс хаях гэсэн адал явдалтангууд, манай дайснууд ийм цуу яриаг тарааж байгаа буй заа. Иймэрхүү мэдээ нь ард олны дунд янз бүрийн үзэл бодол бий болгож байгаа учир ийм байдлыг Монгол улсад суугаа ЗОУ-ын бүрэн эрх барих төлөөлөгч Таны сонорт хүргэж, шаардлагатай гэж үзэхүл Хэнтэй уулзахыг хэлж өгнө үү. Үнэн байдлыг жинхэнээр нь хэвлэлд тавьж, ард олны дундах үл ойлгох байдлыг арилгахад дөхөм үзүүлэх буй заа хэмээн найднам.» гэжээ.

Ерөнхий сайд Цэрэндорж 1923 оны 11 дүгээр сард «Монгол улс тусгаар тогтнолоо хамгаалахын тулд хэрэг гарвал зэвсэг барин тэмцэхэд бэлэн байна» гэж мэдэгдэж байв. Тэрчилэн манай төлөөлөгчид удаа дараа Бээжинд очиж, Хятадын удирдах хүмүүстэй

уулзан хоёр улсын харилцааны асуудлаар санал бодол солилцож байлаа.

1924 оны 5 дугаар сарын 31-нд Зөвлөлт Орос, Хятад улсын хооронд байгуулагдсан Монголын асуудлаарх тусгай хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд «Монгол улс бол Хятадын бүрэлдэхүүн хэсэг мөн» гэснийг манай монголчууд ихэд эсэргүүцэн дургүйцэж байсан авч хүчтэний өмнө хүчгүй нь буруутайн үлгэрээр яаж ч чадахгүй байлаа.

1924 оны Орос, Хятадын хэлэлцээртэй холбогдуулан элчин төлөөлөгч Васильев 1924 оны 6 дугаар сарын 19-нд Чичеринд дараах захидлыг явуулжээ. «Хятадтай байгуулах хэлэлцээрийн тухай Монголын засгийн газарт албан ёсоор тугаа сая мэдэгдлээ. Би Монголын засгийн газрынханд Ринчино, Япон Данзан, ГЯЯ-ны сайд Жамсраног байлцуулан мэдээлэл хийлээ. Караханы цахилгаан утасны дагуу нэг цагийн туршид уужуу тайван мэдээлэл хийлээ. Гэрээний бичвэр болон тодорхой баримт байхгүй учир мэдээллээ санал солилцох яриа болгон өргөжүүлсэнгүй. Монголын засгийн газар байдлыг тодруулах зорилгоор өөрийн хүнээ Бээжин рүү явуулахаар шийдвэрлэсэн тухай өнөөдөр олж мэдлээ» гэж бичсэн байлаа.

Элчин сайд Васильев төвдөө илгээсэн бас нэгэн захидалдаа «Караханы хэлэлцээнээс болоод монголчууд бидэнтэй хүйтэн харьцах болов. Таны удирдамж дагуу боллоцоо бүхнийг ашиглаж монголчуудад бүх юм хуучнаараа байна гэдгийг ойлгуулахыг хичээж байна» гэж бичсэн байдаг.

1922 онд Монгол улс, Зөвлөлт Орос улс хоёр бүрэн эрх барих төлөөлөгчийн газраа нийслэл хотууддаа харилцан нээж, Монгол улсын анхны бүрэн эрх барих төлөөлөгчөөр гүн Даваа, Зөвлөлт Орос улсын төлөөлөгчөөр Любарский нар тохоон томилогдов. Манай төлөөлөгчийн газар 4 орон тоотойгоор ажиллаж эхэлжээ.

1922 оны 1 дүгээр сард Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Д. Бодоо өвчний хэмээн албан ажлаасаа чөлөөлөгдөн оронд нь ГЯЯ-ны сайдаар Б.Цэрэндорж томилогдов. Засгийн газрын шийдвэрээр ГЯЯ ны сайдын албан тушаалыг ерөнхий сайд хашиж байсныг болиулжээ. Ингээд 1922 онд ГЯЯ-нд тэргүүн сайдаар Цэрэндорж, дэд сайдаар гүн Жигмэддорж, эрхэлсэн түшмэлээр бэйс Амар, орос орчуулагч түшмэлээр Батхаан, туслах түшмэлээр гүн Дашаа, гүн Гүржав, Самбуу, Түмэнбаяр, Бат-Очир, туслах түшмэл орлосноор Магсаржав, Сүндэвдоной, Эришжав, Амгалан, Өсөхбаяр, Навааннамжил, Даваа (мээрэн), хятад орчуулагч түшмэлээр Элбэгбат, орос орчуулагч түшмэлээр Попов, бичээчээр Догсүрэн, Дэлэгням, Цэвэгжав нарын 37 хүн ажиллаж байв.

1921 оны 11 дүгээр сарын 5-нд Монгол Зөвлөлийн засагт Орос улсын хооронд байгуулсан гэрээний дагуу Ховд, Улиастай, Алтанбулаг, Баянтүмэн, Мөрөн, Сайншанд зэрэгт 1922-1941 онуудад оросын консулууд ажиллаж байв.

1923 оны 1 дүгээр сарын 6-нд Монгол, Барга хоёрын ард иргэдийг харилцан найрамдалтай нутаглуулах талаар 6 зүйлт түр гэрээ бичиг байгуулж, энэ тухай аймаг хошуудад зарлал бичиг тараав.

1924 онд БНМАУ-ыг тунхаглан зарласны дараа ГЯЯ-нд зарим өөрчлөлт хийж, ГЯЯ-ны сайдаар С.Гиваабалжир томилогдон жил хэртэй ажилласан байна.

1924 оны 7 дугаар сард америкийн бизнес эрхлэгч Рой Андерсон Москвад очиж ЗХУ-ын гадаад хэргийн ардын комиссар Чичеринтэй уулзахдаа Хятадын, түүний дотор Монголын асуудлаар их гүрнүүдийн олон улсын хурал зарлан хуралдуулах санал тавьж байжээ.

1925 онд ГЯЯ-ны удирдлагад дахин өөрчлөлт хийж, сайдаар В.Дорлигжав томилогдов.

1925-1929 онд Монгол улс тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, гадаадын олон улс оронтой харилцаа тогтоох талаар шургуу ажиллаж, манай гадаад харилцааны алба нэлээд бие даасан ажиллагаатай байжээ. Энэ үед ГЯЯ-нд эрхэлсэн түшмэлээр Даваа, өрнөд хэлтсийн эрхэлсэн түшмэлээр Амгалан, дорнод Хэлтсийн эрхэлсэн түшмэлээр Чимидцэрэн, орос үсгийн дээд зэргийн орчуулагчаар Дашаа, англи үсгийн дээд зэргийн орчуулагчаар Гошис, туслах түшмэлээр Намсрай, Паландорж, Лоройсамбуу, Цэнджав, хоёрдугаар зэргийн түшмэлээр Элбэгбат нарын олон хүн ажиллаж байв. Гэхдээ дипломат алба зөвхөн гяя-аар хязгаарлагдаж байсангүй.

1925 онд Дамбадорж, Амар нар Бээжинд Хятад Оросын хэлэлцээний дүнгийн талаар тодорхой мэдээлэл олж мэдсэний дээр Хятад болон бусад улс оронтой харилцаа тогтоох талаар ажиллав.

1925 онд Дамбадорж Монценкоопын нэрээр Итали, Франц, Германаар явж, тэдэнтэй харилцаа хөгжүүлэх, оюутан сургах боломжийг тандав. Англи орох бодолтой байсан боловч бодлоо хэрэгжүүлээгүй байна. Албан ёсны гэрээ хэлэлцээр байгуулаагүй ч 1926 оноос Герман, Францад оюутан сургаж эхлэв. Мөн Германаас зарим үйлдвэрийн тоног төхөөрөмж авч эхлэв. 1927

оноос Берлинд худалдааны төлөөлөгчийн газраа нээн түр хугацаагаар ажиллуулж байв.

1926 онд Москва дахь манай худалдааны төлөөлөгч Сампилон Лондонд очиж, Монгол, Английн хооронд эдийн засаг, худалдааны харилцаа хөгжүүлэх боломжийг тандан ярилцжээ. Тэр үеэрээ түрүүнд Монголд экспедицээр ирж ажиллахад нь танилцсан ЗХУ-ын элчин сайд Майскийтай уулзаж, түүнээс туслалцаа авсан тухай мэдээ байдаг. Майский түүнийг Лондон хоттой танилцуулж, »Дейли Манчестер», «Манчестер Гардиан» сонинд ярилцлага өгөхөд нь туслажээ. Мөн Лондон дахь Хятадын мэдээллийн Товчооны дарга Малонтой Майскийн хамт уулзжээ.

1926 онд Түвдтэй найрамдлын гэрээ, харилцаа тогтоолгохоор Гомбо-идшин тэргүүтэй төлөөлөгчдийг мордуулжээ. (Төлөөлөгчид 1927 оны намар Түвдийн нийслэл Лхас хотод хүрч, нэлээд хүлээсний эцэст манай талаас санал болгосон 6 зүйлт мэдэгдлийг хүлээн авах боломжгүй гэсэн хариу авч ирсэн байна.)

Америктай харилцаа тогтоох талаар нэлээд оролдлого хийж байсан авч, Бодоо нар цаазаар авхуулсан, нөгөөтэйгүүр оросын тал тэдэнтэй харилцахыг таашаахгүй байсан зэргээс бүтэлгүйтэж байлаа.

1925-1929 онд ЗХУ-д суух бүрэн эрх барих төлөөлөгчөөр хашир дипломатч Б.Буянчуулган томилогдон, Монгол, ЗХУ-ын харилцааг хөгжүүлэх хийгээд гадаад улс оронтой холбоо тогтооход түлхүү анхаарч ажиллаж байв. Тэрвээр Перс, Францын элчин сайд нартай нэг бус удаа уулзсан бөгөөд аль аль нь Монгол улстай харилцаа тогтоож болох талаар санал илэрхийлж байсны дээр Францын элчин сайд Эрбэт манай элчин төлөөлөгч Буянчуулганд «ЗХУ-ын засгийн газрын дэргэд БНМАУ-ыг төлөөлөн суугаагийн хувьд ЗХУ-д суугаа Францын элчин сайд түүнтэй харилцаж байгаа бөгөөд тэр утгаараа Франц улсын засгийн газарт суугаа БНМАУ-ын төлөөлөгч болж байна» гэж цохон тэмдэглэсэн байдаг. Нөгөөтэйгүүр Элчин сайд Эрбэт Дээд Үд - Хиагт - Улаанбаатарын хооронд баригдах төмөр зам, түүнийг Хаалган хүртэл үргэлжлүүлэх эсэх талаар сонирхон Улаанбаатар, Хаалганы хооронд төмөр зам барих эрхийг америкчуудаас авахыг өөрийн засгийн газартаа санал болгоход бэлэн байгаа тухай дурдаж байжээ.

1926 онд Монгол улс Тагна Тува улсын хооронд найрамдлын гэрээ бичигт Улаанбаатар хотноо гарын үсэг зурсаны дээр Тувад байнгын төлөөлөгчийн газраа 1928 оноос нээн ажиллуулж эхэлжээ.

1926 оноос ГЯЯ-ны төлөөний түшмэдийг хөдөө орон нутагт томилон ажиллуулах тухай засгийн газрын тогтоол гарчээ. (1931 оноос тусгай хүн томилохыг зогсоож, орон нутгийн захиргааны дарга нарт хавсруулах болсон байна)

1927 онд Улсын бага хуралд Гадаад явдлын яамнаас оруулсан илтгэлд «Зөвлөлийн засагт Холбоот улстай нэлээд харилцаж буй. Герман улстай бага сага харилцан, эдгээр улсуудаас цэргийн ба эд боловсруулах сурагч, инженер ба хүмүүн малын эмнэлгийн тухайд боловсронгуй эрдэмтэн хүмүүнийг урин ирүүлж хэрэглэх ба, мөн СССР, Герман, Франц улсад хүүхдийг явуулж эрдэм соёл, аж үйлдвэр, хоршооны зэрэг сургуульд оруулж боловсруулан Совет, Герман улсаас албаны газруудад хэрэглэх машин зэрэг эд юмыг худалдан авч харилцан туслалцах хоршооноос Хятад, орос газруудад мал ба түүхий эд нэвтрүүлэн худалдаалж мөн газруудаас эд бараа нэвтрүүлэн авчирч Европ ба Манжуур зэрэг газар нэвтрүүлэх юмыг Сэлэнгэ голоор СССР улсын галт онгоцоор нэвтрүүлж, Банкаас Госбанкууд лугаа холбоотой болж, дотоодоос гадаадад нэвтрүүлэх мөнгийг харилцах банкуудад уламжлан гуйвуулж, мөн банкуудаас өөрийн банкны нэр дээр даалгаж, гуйвуулсан мөнгийг өр төлөх зэргээр харилцаж буй бөгөөд аливаа улс лугаа найрамдал холбоо байгуулах ба эзэрхий хөрөнгөтөн лугаа харилцах аваас ашиг хорыг хянан болгоомжлох, бас ч тэдний дотроос улс төрийн ба эдийн засгийн тухай хэрэгт шунах өнгөлзөх этгээд хэрвээ буй ахул тухай дор эсэргүүцэж устгах явдлыг арга сүвэгчилэн гүйцэтгүүлэхийг хичээн буй. Төвд улстай найрамдал холбоог зузаатгах явдлыг цагийн байдалд гүйцэтгэх ба тус улсаас Төвд улсад одуулсан элчин сайдаас захидал мэдээ аваагүй боловч харъяат яамнаас сонин сэтгүүл зэрэг бичгийг аяны хүмүүнээр харилцан хүргүүлж хэл авалцаж байх явдлыг арга сүвэгчилэн гүйцэтгүүлж байхыг бодолхийлж буй.» гэж тэдэглэжээ. Тэр үед Монголд Хятад, орос, төвд, япон 5, герман 11, польш 5, франц 13, гуулиан 1, эстони 1, чехословак 1 тус тус оршин сууж байв. ЗХУ, Тагна Урианхай, Дундад иргэн улстай хил тогтоох оролдлого хийж, Гадаад яамны төлөөний тусгай төлөөлөгчийг Жавхлант хот, Хан Хэнтий уулын аймаг, Баянтүмэн хан уулсын хошуунд суулгаж, тодорхой удирдамжаар хангаж байв. Москва хотноо суугаа ЭСЯ-ыг удирдах ажлыг нягт явуулахын хамт, ЭСЯ-наас ирүүлсэн гадаад улсуудын холбогдох мэдээ баримтыг орчуулан эмхэтгэн лав нэгдүгээр дэвтрийг хэвлэжээ. Хоёрдугаар дэвтрийг хэвлэхээр завдаж байсан авч амжаагүй бололтой.

1927 онд дипломат, албан, энгийн паспортын загварыг анх гарган хэрэгжүүлж эхэлжээ.

1927 онд Кантоны засгийн газартай хэлэлцээ хийхээр НТХ-ны нарийн бичгийн дарга Гэлэгсэнгээ, дотоод хэргийн яамны сайд А.Амар, гадаад яамны сайд Дорлигжав, Амагаев нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг явуулав. Энэ үеэр арван зүйлт гэрээ байгуулахыг хятадын талд санал болгохоор төлөвлөж байв. Уг гэрээний төсөлд хоёр тал бие биеийн тусгаар тогтнолыг харилцан хүлээн зөшөөрөх, төлөөлөгчид харилцан суулгах, бие биедээ цэргийн туслалцаа үзүүлэх зэрэг зүйл орсон байна.

Хамгийн сүүлчийн зүйл нь 1919-1920 онд Аньфугийн бүлэглэлийн генерал Сю шүжан Монголыг эзэлснээс болж учруулсан хохирлыг арилгах төлбөрт 10 сая долларыг төлөх тухай заалт орж байв.

1928 онд Монголын нутагт оршин суугаа орос нарын тухай Протокол, Алтанбулагаар дамжин ЗХУ-ын хил хүртэл зорчигчид болон бараа тээвэрлэх тухай хэлэлцээр зэргийг байгуулав.

Чингээд 1928 он гэхэд Монгол улс гадаад харилцааны хувьд нэлээд бие даасан байдалтай болсон байлаа. Гадаадын хэд хэдэн улстай албан бус ч гэсэн харилцаатай болж, Өвөр Монголтой хэл амаа ойлголцож эхэлжээ. Монгол, Оросын харилцаа олон улсын хууль цаазны хэр хэмжээнд хүрэх аястай болж, гадаадынхны зааварчилга болгоныг үг дуугүй даган захирагддагаа больж, 1924 1925 онд засгийн эрхэнд орсон зүүний жигүүрийнхний үйл ажиллагаа суларчээ. Тиймээс Улаанбаатар дахь ЗХУ-ын бүрэн эрх барих төлөөлөгчөөс 1928 оны 7 дугаар сарын 16-нд Ворошиловт / тэрвээр ЗХУКН-ын Төв Хорооны УТТ-ны дэргэдэх Монголын комиссыг тэргүүлж байв/ бичсэн албан тоотдоо «Монгол улс бидэнд дайсагнасан улс болох дөхөж байна. Фынтэй хэлэлцээр байгуулах шатандаа ороод байна. Иймээс Сибирийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг нэлээд буурьтайхан бодох цаг хэдүйнээ болжээ. Энэ улс манай түшиц газар гэж бид тооцон манайхаас тэнд өөр бодлого явуулж байсан юм. Одоо байдал өөр болж, манай хил хамгаалалтгүй болж задгайрлаа. Үүсч бий болсон шинэ нөхцөл байдалтай холбогдуулан Монголтой дэрлэсэн хил дээр хилийн хамгаалалтын алба бий болгох үүднээс Улс төрийн хамгаалалтын улсын албаны удирдах газарт олгох хөрөнгө мөнгийг нэмэх шаардлагатай байна. Үүнээс ч илүү ноцтой зүйл бол Сибирь дахь манай зэвсэгт хүчний асуудал юм. Дайсагнагч улстай ийм ойртож байгаа нь нэгд Сибирийн төмөр замыг аюулд учруулж байна. Хоёрт, Сибирь дахь зөвлөлтийн эсрэг этгээдүүдэд шинэ нөхцөл байдлыг үүсгэн, тэдэнд ойроос тусламж, хүч сэлбэх бололцоо олгох болно. Гол асуудал бол Сибирийн төмөр замдаа биш, харин Сибирь дэх зөвлөлт засгийн тухай асуудал юм.

Тиймээс Сибирь дэх манай Зэвсэгт хүчинд ямар өөрчлөлт, нэмэлт үзүүлэх асуудлыг тун яаралтай шийдэх хэрэгтэй байна. Би өөрийн мөхөс чадлынхаа хэрээр та бүхэнд туслах болно» гэж бичиж байлаа.

Ер нь Алс Дорнодод Япон улс хүчирхэгжиж, ЗХУ нөлөөгөө алдаж болзошгүй гэдэгт туйлын эмзэг хандаж байсан байна. Монголын асуудал эрхэлсэн тусгай комиссыг байгуулах шийдвэр 1926 онд ЗХУКН-ын Төв Хорооны УТТ гаргаж, даргаар нь Каменевыг тавьжээ. Үүгээр Монголтой холбогдох бүх асуудлыг шийдвэрлэж байлаа. Энэ бол маш их эрх мэдэл бүхий байгууллага байсан бөгөөд Монголын дотоод хэрэгт шууд оролцдог байгууллага байсан юм. Комиссын бүрэлдэхүүнд Коминтерн, ГХАКГ, ГхудАК-ын Газраас төлөөлөгч оролцдог. Үүний зэрэгцээ ГХудАКГ-ыг дэргэд худалдаа эдийн засгийн асуудал эрхэлсэн дэд комисс ажиллаж байв.

Коминтернийн даалгавраар МАХН-ын VII их хурал 1928 онд хуралдаж, баруунтан А.Амар, Ц.Дамбадорж, Н.Жадамба, ГЯЯ-ны сайд В.Дорлигжав, болон Ц.Жамсран, Цэдэн-Иш нарын эх орончдыг «Хөдөөний» бүлгийнхнээр сольжээ. ГЯЯ-ны сайдаар Ц.Гүрсэдийг томилов.

1929 оны 6 дугаар сарын 27-нд Коминтерн, ЗХУКН-ын шахалтаар «БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын харилцааны үндсэн зарчмууд хэлэлцээр байгуулагдав. Хэлэлцээрт монголын талаас Ерөнхий сайдын орлогч бөгөөд аж ахуйн яамны сайд Дамдинсүрэн, ГЯЯ-ны сайд Гүрсэд, Улсын Бага Хурлын гишүүн Гэндэн нар зөвлөлтийн талаас бүрэн эрх барих төлөөлөгч Охтин, худалдааны төлөөлөгч Ботвиник, ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Климов нар гарын үсэг зуржээ. Өнгөцхөн харахул аж ахуйн чанартай мэт боловч цаагуураа улс төр-эдийн засгийн гүн гүнзгий утга агуулгатай бөгөөд үүгээр монголын тал гадаад улс гүрэнтэй харилцах бүх эрхээ зөвлөлтийн талд шилжүүлсэн байна.

Үндсэн хэлэлцээрийн 2 дугаар зүйлд «Монгол улсын засгийн газар нь харъяат улсын ба хоршооны газруудын бэлтгэсэн түүхий Эдийг гадаадад гаргаж худалдахад юуны өмнө СССР улсад худалдахыг сануулна.

СССР-ын засгийн газар нь Монголын малын ба малын бус зүйлийн аж ахуйгаас гаргах бөгөөд гадаадын дэлгүүрт худалдах түүхий эдийг худалдан авахыг хичээнэ» (хэлэлцээрийн орос бичвэр дээр бүх түүхий эд, зүйлсийг худалдан авахыг эрмэлзэнэ гэж бичсэн буй. ГХТА, ф. 117, Р.Я.)

Хэлэлцээрийн 11 дүгээр бүлэгт «Монгол ард улсаас нийтлэн тунхагласан улс төр ба аж ахуйн зүйлүүдийг гүйцэтгэх явдалд урьд олсон үлгэр туршлага бүхий тул Холбоот улсаар эдийн засаг, эрдэм соёл, улс төрийн хэргүүдийн тухай Монголд сургаж зааж туслах нь зүйтэй хэмээн Монгол улсын засгийн газраас үзэж байгаа ба ЗСБНХУ-ын засгийн газар Монгол улсын засгийн газрын хүссэнийг гүйцэтгэхээр зөвшөөрөв» гэжээ.

Мөн онд ЗХУ-ын сургагч, зөвлөхүүдийн тухай хэлэлцээр байгуулагдав.

Ерөнхий сайд Б.Цэрэндорж таалал төгсч, нөгөөтэйгүүр дээрх хэлэлцээрийн зарим тодорхой заалтыг эсэргүүцэн Амар, Жадамба, Дамбадорж нарыг баруунтан болгож, албан тушаалаас нь өөрчилсөн (нутаг заан суулгасан) нь хэлэлцээрийг төвөггүй байгуулахад хүргэжээ (Энэхүү хэлэлцээрийг албан ёсоор өдгөө хүртэл цуцлаагүй байгаа аж.)

1930 оны 1 дүгээр сарын байдлаар Гадаад яам:сайд Гүрсэд, эрхэлсэн түшмэл Гомбожав, дорнод хэлтсийн эрхэлсэн түшмэл Амгалан, өрнөд хэлтсийн эрхэлсэн түшмэл Буянчулуун, нягтлан бодогч Элбэгбат, орос үсгийн орчуулагч Базар, англи хэлний орчуулагч Гошис, тусгай албанаа яваа туслах түшмэл Самбуу, машины бичээч Очир, жинхэнэ бичээч Очир, Эрхэмбаатар, хавсарсан бичээч Лхамсүрэн, Дугарсүрэн, Цэдэндамба, жинхэнэ бичээч Сундуйсүрэн, хаминдант бөгөөд нярав Зундуй, зарлага Дамба, галч Нэмэх, жолооч Сандаг гэсэн нийт 19 орон тоотой байсан бол 1930 оны дунд үеэс цомхотгол хийж 13 орон тоотой болгосны дээр ГЯЯ-ны сайдаар Х. Чойбалсан томилогджээ. Тэрвээр 1930-1931 онд ГЯЯ-ны сайдаар ажиллаж байв.

1932 онд Засгийн газрын тогтоолоор гадаад харилцааны цар хүрээ хумигдсаныг харгалзан ГЯЯ-ны орон тоог хасч 6 болгов. ГЯЯ ны сайдын албан тушаалыг ерөнхий сайд давхар хаших зохион байгуулалтад оруулжээ. Энэ үед ГЯЯ орлогч сайд, өрнөд, дорнод хэлтсийн дарга, бичээч, жолооч буюу сайдтайгаа нийлээд ердөө 4 дипломатчтай байлаа.Өрнөд, дорнод хэлтэс гэдэг нь нэг нэг л ажилтан байсан бөгөөд энэ маягаар 1946 он хүртэл явж ирсэн юм.

1932-1946 он хүртэлх Монгол улсын дипломат албаны үйл ажиллагаа туйлын хязгаарлагдмал байдалд явж ирсэн он жилүүд бөгөөд 1934 онд ЗХУ-тай харилцан туслалцах тухай аман хэлэлцээр, 1936 онд харилцан туслалцах тухай Протокол тус тус байгуулагджээ. Энэ хугацаанд манай ГЯЯ-ны гол гүйцэтгэж байсан ажил үүрэг бол Москва, Кызыл дэх ЭСЯ-даа удирдах, Улаанбаатар дахь ЗХУ,

Тувагийн ЭСЯ-тай их төлөв аж ахуйн хэргээр харилцах, ЗХУ-аас мэргэжилтэн захиалах, консулын харилцаа эрхлэх (паспорт, Виз олгох)-д оршиж байлаа.

Монгол-Манжуурын хооронд болсон 1935-1937 онд болсон хэлэлцээнд хэдийнээр ГЯЯ-ны орлогч сайд Г.Самбуу тэргүүлэн оролцож байсан боловч ГЯЯ-ны дипломат бүрэлдэхүүний оролцоо тун хомс харагддаг.

1941 оны 6 дугаар сараас БНМАУ-аас ЗСБНХУ-д суугаа бүрэн эрх барих төлөөлөгчийг Онц бөгөөд бүрэн эрхт Элчин гэж нэрлэх болжээ.

1941-1945 онд ЗХУ-д туслах, монголын ард түмний тусламжийн барааг цуглуулах ажлыг зохион байгуулах, дэлхийн хоёрдугаар дайны тухай мэдээллийг ард олонд хүргэх үүрэг ГЯЯ-нд нэмэгджээ.

1944 онд Тагна Тува улс ЗХУ-д нэгдэн орсон учир Улаанбаатар дахь ЭСЯ нь хаагдсан бөгөөд манай улс Кызыл хотноо ажиллаж байсан ЭСЯ-аа татан буулгасан байна.

Дэлхийн томоохон улс гүрнүүд хэдийвээр Монголыг сонирхож байсан ч манай зүгээс ямар нэгэн алхам хийх бололцоо байснгүй. «Фар истерн экономик ревью» сэтгүүлийн 1932 оны 6 дугаарт нийтлэгдсэн «Хувэрийн номлолын туршилт» гарчигтай Георг Бромсон Ригийн өгүүлэлд хэдийгээр Америк болон бусад томоохон улс гүрэн Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөшөөрөөгүй ч тусгаар улс байхыг үгүйсгээгүй юм. Тэр улсын бүх худалдаа, эдийн засгийг Орос улс гартаа бүрэн оруулаад байгааг буруушаагаагүйгээр бид өөрийн зүс царайг хадгалж байна хэмээн шүүмжлэн бичиж байв.

1945 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч Уэльс Монголд ирж, улс орны байдалтай танилцан, хэтээсээ туурга тусгаар улс байсан Монгол орны хувь заяаны талаар сонирхоод нутагтаа буцаж очсон хойноо Монголын тухай сүүлийн 30-аад жилд ЗХУ-ын дагуул маягтай улс болсон хэмээн очоод мэдээлсэн байдаг.

Дэлхийн хоёрдугаар дайн төгсгөлийнхөө шатандаа орж байсан үед дайны дараах хүчний харьцааны талаар том гүрнүүдийн хооронд хэлэлцээ яриа болж байх үед Монголын асуудал ч хөндөгдөж байв.

Рузвельт, Черчиль, Сталин нарын хооронд 1945 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Ялтад болсон хэлэлцээгээр Японы эсрэг ЗХУ дайнд орох болзлын нэгэнд Монголын статус кво (оршин тогтож буй

байдлаар нь ) хэвээр үргэлжлүүлэн бататгах, буюу «тэр үеийнх нь байдлаар» тусгаар улс болохыг зөвшөөрсөн билээ.

ЗХУ, Дундад иргэн улсын хооронд 1945 оны 8 дугаар сарын 14-нд Монгол улсын тусгаар тогтнол хийгээд газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх» тухай ноот бичиг харилцан солилцов. Хятадын талын ноотод «Японыг дарсаны дараа монголын ард түмний нийтийн хүсэл, энэ эрмэлзлээ батлах ахул Дундад Улсын засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хилээр нь зөвшөөрч байна» гэсэн мэдэгдэл хийжээ.(ГХТА, Ф.05, х\н)

1945 оны 10 дугаар сард Монгол даяар улс орон цаашид хэрхэн орших асуудлаар санал асуулга явуулж, манай ард түмэн тусгаар тогтнолоо илэрхийлсэн хэвээр хадгалан хөгжих хүслээ илэрхийлсэн юм. Санал асуулгын дүнг ЗХУ, Хятад улсад албан ёсоор мэдэгдсэний дараа 1946 оны 1 дүгээр сарын 6-нд Чан Кайшигийн засгийн газар Монгол улсыг хүлээн зөвшөөрч, мөн оны 2 дугаар сарын 10-нд БНМАУ, Дундад иргэн улсын хооронд дипломат харилцаа тогтоох болон дипломат төлөөлөгч харилцан суулгах тухай ноот бичгийг солилцжээ.

Хоёрдугаар дайны дараа дэлхий дахинаа үүсэн бий болсон бодит байдал хийгээд Монгол улсын тусгаар тогтнолыг хоёр хөрш хоёул хүлээн зөвшөөрсөнтэй уялдуулан дипломат албыг шинэчилэн зохион байгуулах тухай БНМАУ-ын Засгийн газрын 1946 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 9 дүгээр хурлын тогтоол гарав. Үүгээр ГЯЯ-ыг 36 нэгжтэйгээр баталж, ГЯЯ-ны орлогч сайдаар Н.Лхамсүрэн, сайдын туслагч Л, Норовсамбуу, Европын хэлтсийн даргаар С.Гомбосүрэн, Дорнод хэлтсийн даргаар Ж.Самбуу, протокол ангийн эрхлэгчээр Б.Жаргалсайхан нарыг томилсон байна. Энэ үед ГЯЯ европын хэлтэс (ЗХУ, бусад улстай харилцах), дорнод хэлтэс (Хятад, Азийн бусад улстай харилцах), тогтоол хэлтэс (гэрээ эрх, ёслол, дотоод асуудал), хэрэг эрхлэх газартай байв.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1946 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 93 дугаар хурлын тогтоолоор БНМАУ-ын ГЯЯ-ны ажилтнууд болон гадаадад суугаа элчин сайд, ЭСЯ-ны дипломат ажилтны зэрэг дэв, цолыг анх тогтоожээ. Үүнийг 1956 онд шинэчилэн тогтоосон байна. Дипломат ажилтнуудын цол дэвийг анх тогтоохдоо дэлхийн улс орнуудын жишгийг харгалзан тэргүүн зэргийн нэгдүгээр нарийн бичгийн дарга гэх мэтчилэн болхи орчуулгын үг хэрэглэж байсны дээр албан тушаал/ цол дэвийн хооронд ялгаа ажиглагдахгүй байсныг 1969 онд их эрдэмтэн зохиолч Б.Ринчин нарын эрдэмтэн мэргэдийн зөвлөснөөр өөрчлөн түшээ, дэд ба тэргүүн итгэмжит, дэд ба тэргүүн шадар, элчин, элчин сайд гэсэн

оновчтой үгийг сонгон хэрэглэх болсон билээ. 1947-1953 онд ГЯЯ-ны дипломат ажилтнууд формын хувцастай байв.

1946 оноос хойш дипломат алба ийнхүү шинэчлэн зохион байгуулагдаж, ажлын цар хүрээ жилээс жилд өсөн нэмэгдсээр ирлээ.

1946 онд Сүхбаатар хотноо ГЯЯ-ны төлөөлөгчийн газар нээж Дамцагийг төлөөлөгчөөр ажиллуулжээ.

БНМАУ-ын ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Чойбалсан тэргүүтэй төлөөлөгчид 1946 оны хоёрдугаар сард ЗХУ-д албан ёсоор айлчилж, хоёр орны харилцааны асуудлаар зөвлөлтийн талтай хэлэлцээ хийв. Энэ удаад монголын төлөөлөгчдийг гадаад улсын албан ёсны төлөөлөгчид хэмээн үзэж олон улсын дипломат ёс жаягийн дагуу хүлээн авсан юм. Хэлэлцээний эцэст 1946 оны 2 дугаар сарын 27-ны өдөр БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд нөхөрлөл ба харилцан туслалцах тухай Гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд энэ нь чухамдаа цэргийн хамтын ажиллагааны гэрээ байлаа. Үүний зэрэгцээ эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулав.

Санал асуулгын дүн гарсаны дараахан 1945 оны 11 дүгээр сараас манайхан Москвад суугаа ЭСЯ-нд Чехословак, Югослав, Дани, Польш зэрэг орны ДТГ-ууд хандан баяр хүргэхийн сацуу нэрийн хуудсаа ирүүлж, танилцахыг хүсч байжээ. Югославын элчин сайд биечлэн танилцах, улмаар үндэсний баярын хүлээн авалтдаа урих зэргээр нааштай хандаж эхэлжээ. Энэ тухай Москвад сууж байсан элчин сайд Ж.Самбуу төвдөө мэдээлж хэрхэх талаар асууж байв. Ардын ардчилсан орнуудтай найртай харилцаж, аль болохоор дотно холбоотой байхыг төвөөс түүнд даалгаж, улмаар ардын ардчилсан бусад улс орны зүгээс тиймэрхүү асуудал тавиваас аль болох ойртож ажиллахыг зөвлөжээ.

Бие даасан Монгол улс гадаад харилцаагаа явуулахад мэргэшилтэй боловсон хүчин туйлын дутагдаж байлаа. Манай улсын хамаг мэдлэгтэй, туршлагатай боловсон хүчин хэлмэгдлийн хар шуурганд өртөж, жинхэнэ дадлага туршлагатай мэргэшлийн дипломатчид, улс төрчид бараг үгүй болсон байсан юм. 1911-1946 онд ГЯЯ-ны сайдаар ажилласан 9 хүнээс 7 нь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн буюу ёс бусаар егүүтгэгджээ. Иймээс боловсон хүчин бэлтгэх явдал чухлаас чухлаар тавигдаж, МУИС-д оюутан сургахын сацуу гадаад улс гүрэнд оюутан явуулж эхлэв. 1946 онд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуульд М. Дүгэрсүрэн, С. Пүрэвжав, О.Хосбаяр, С.Лочин, Ш.Бира нарыг явуулснаар уг сургуульд хагас зуун жил хүнээ сургах ажил эхэлжээ.

Ийнхүү 1946 оноос шинэчлэгдэн байгуулагдсан дипломат алба юуны өмнө гадаад харилцаагаа өргөтгөн, Дэлхийн олон улс лугаа харилцаа тогтоохын сацуу харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байлаа.

1948 онд БНАСАУ-тай, 1949 оны 10 дугаар сард БНХАУ-тай, 1950 оны 4 дүгээр сард БНАГУ, Польш, Болгар, Чехословак, Унгар, Румынтай дипломат харилцаа тогтоов.

1950 оны 4 дүгээр сарын 4-нөөс БНМАУ, ЗСБНХУ хоёр элчин төлөөлөгчийн газруудынхаа түвшинг ахиулж Элчин сайдын яам болгохоор шийдвэрлэв.

1950 оны 7 дугаар сараас БНМАУ, БНХАУ хоёр ЭСЯ-даа харилцан Бээжин, Улаанбаатарт нээн ажиллуулахаар тохиролцон, манай улсын анхны элчин сайдаар Б.Жаргалсайхан Бээжинд хүрэлцэн очиж, мөн сарын 3-нд Хятадын төрийн тэргүүнд итгэмжлэх жуух бичгээ гардуулан ажлаа эхэлжээ. БНХАУ-ын элчин сайд Цзи Ятай 7 дугаар сарын 10-нд итгэмжлэх жуух бичгээ барьжээ. БНМАУ аас БНАСАУ-д суух элчин сайдаар Ж.Самбуу томилогдон 1950 оны 8 дугаар сарын 11-нд итгэмжлэх жуух бичгээ барьжээ.

Манай улсын гадаад харилцаа өсч байгаатай холбогдуулан 1950 оны 6 дугаар сард ГЯЯ-ны зохион байгуулалтыг өргөтгөж, хоёр орлогч сайдтай болгож, ерөнхий нарийн бичгийн даргын газар, консулын хэлтэс, нууцын тасгийг шинээр байгуулж, ёслолын анги, шинэ хүчний тасгийг хэлтэс болгосны дээр бүх хэлтэст орлогч эрхлэгч томилжээ. Мөн ГЯЯ-ны сайдыг ерөнхий сайд хавсарч байсныг дагнуулах болж ГЯЯ-ны сайдаар Н.Лхамсүрэнг, орлогч сайдаар Л.Норовсамбуу, Ж.Самбуу нарыг томилжээ. 1953 онд ерөнхий нарийн бичгийн даргын газрыг татан буулгаж, оронд нь гэрээний хэлтсийг байгуулсан юм.

1951 онд БНМАУ-ын консулын дүрэм, гадаад паспортын дүрэм, тус улсад суугаа гадаадын элчин төлөөлөгч, консулын эрх хэмжээний тухай заавар зэргийг боловсруулан баталж, мөрдөж эхлэв.

1952 онд БНХАУ-тай эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай, 1955 онд Албани улстай, 1956 онд ЗХУ, Румын, БНАСАУ-тай соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр, Чехословактай шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулагдав.

1954 онд БНАВУ-тай, 1955 онд Энэтхэг улстай, 1956 онд Бирм, Югослав, Индонези улстай дипломат харилцаа тогтоов.

1956 онд Прага, Делид, 1957 онд Будапештэд ЭСЯ-даа нээн ажиллуулж эхлэв.

1956 онд ГЯЯ-наас эрхлэн «сонсгол мэдээг» гадаад (англи) хэлээр сард хоёр удаа гаргаж байв.

1957 онд Хөх хотод БНМАУ-ын Ерөнхий консулын газрыг нээн ажиллуулж эхлэв. (1959 онд хаасан)

1957 онд Чехословак, БНАГУ-тай найрамдал, хамтын ажиллагааны гэрээ байгуулсан бөгөөд эдгээр гэрээний нэгдүгээр зүйлд тусгаар тогтнолоо харилцан хүндэтгэх, тэгш эрх, дотоод хэрэгт үл оролцох, харилцан ашигтай байх» зарчмуудыг тусган тунхагласан нь Монгол улсаас гадаад улс гүрэнтэй байгуулсан гэрээнүүдэд анхдагч болсон юм. Мөн онд Чехословак, БНАГУ, Болгар, Унгартай соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр байгууллаа.

1957 онд Гана, Тунис, Судан, Малайз, 1958 онд Гвиней, Алжир, 1960 онд Камерун, Того, Сомали, Малгаш, Конго (Киншасса), Нигер, Дагомей, Дээд Вольта, Зааны ясан эрэг, Чад, Төв Африкийн БНУ, Конго (Бразавиль), Габон, Холбооны Нигери, Мали, Лаос, 1961 онд Сьерра Леоне зэрэг улсууд тусгаар тогтнолоо зарласныг хүлээн зөвшөөрч байгааг мэдэгдэхийн сацуу дипломат харилцаа тогтооход бэлэн байгааг илэрхийлжээ.

1958 онд манай улс БНАГУ-д ЭСЯ-аа нээн ажиллуулж эхэлсний дээр БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд консулын конвенц, хоёрдмол харъяалалтай иргэдийн асуудлыг зохицуулах тухай конвенц, БНАВУ, БНХАУ, БНАГУ-тай соёлын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг тус тус байгуулжээ.

1959 онд Вьетнамд байнгын түр хамаарагчийн газраа нээв. Түвшинг нь 1960 онд ахиулж, ЭСЯ болгосон бөгөөд элчин сайд О.Хосбаяр 1960 оны 7 дугаар сарын 4-нд итгэмжлэх жуух бичгээ барьжээ.

1959 онд Варшавт ЭСЯ-аа нээн, элчин сайдаар О.Бат-Очир томилогдон очиж итгэмжлэх жуух бичгээ барьсан юм. Мөн онд БНАГУ-тай шинжлэх ухаан техникийн салбарт, Унгар улстай эрүүлийг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрүүд байгуулав.

1960 онд Гвиней, Куба, 1961 онд Балба, Мали, Алжир улстай тус тус дипломат харилцаа тогтоосны дээр 1960 онд Конакри (Гвиней)-д ЭСЯ-аа нээв. Ирак, Гвиней, Кубатай соёлын сабарт, БНХАУ, БНАСАУ, БНБАУ-тай шинжлэх ухаан-техникийн сабарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, БНХАУ-аас БНМАУ-д эдийн засаг, техникийн тусламж үзүүлэх тухай хэлэлцээрийг БНХАУ-тай тус тус байгуулав.

1960 оны эцэс гэхэд Монгол улс дэлхийн 16 улстай дипломат харилцаатай болж, хорь гаруй улстай тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтооход бэлэн байгаагаа илэрхийлжээ. Монголын дипломат алба төвдөө дал гаруй орон тоотой, сайдын аппарат, өрнөд, Дорнод, олон улсын байгууллага ба гэрээ эрх, хэвлэл мэдээлэл, ёслол, консул, санхүү, үйлчилгээ аж ахуйн гэсэн 9 хэлтэстэй, ерөнхий канцеляр гэсэн нэг газартай байжээ. Төв аппаратад нийт ажиллагсдын 87 гаруй хувь нь дээд хувь нь дээд боловсролтой ажилтнууд байлаа. Хилийн чанадад 11 улсад манай ДТГ ажиллаж байв.

1961 онд БНМАУ НҮБ-д элсэв.

Манай улс НҮБ-д элсэн орохыг хүсч, 1946 онд анх өргөдлөө өгснөөс хойш 1948, 1955, 1956, 1957, 1960 онд өргөдлөө дахин өгөх буюу мэдэгдэл хийх зэргээр уйгагүй хөөцөлдсөний дүнд 15 жилийн дараа монголын талын хүсэл биелэв.

1961 оны 12 дугаар сард Нью-Йорк хотноо БТГ-ыг нээв. Анхны байнгын төлөөлөгчөөр элчин сайд Б. Жаргалсайхан тохоон томилогдож, НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга У Танд 1961 оны 12 дугаар сарын 15-нд ИЖБ-ээ гардуулан ажилдаа оржээ.

Чингэж Монгол улс олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөнөөр гадаад харилцаа тэлэн өргөжих бололцоо нээгдэж, дипломат албаныхан шинэ шинэ зорилтыг хэрэгжүүлэхээр шамдан ажиллаж эхлэв.

XXI ЗУУН «ХЯТАДЫНХ « БОЛОХ УУ?

Д.Баярхүү.\*

70-80-аад оноос ийм асуудал дэлхий дахины анхаарлын төвд байнга явж ирэв. Анхлан 1978 онд Хятад-Японы хооронд Найрамдлын Гэрээг мутарлаж байх үест «XXI зуун Хятад-Японы зуун болно»

\*Улс төр судлаач Д.Баярхүү